



I-VIII/2021

Тархаасан: 2021 оны 10 дугаар сарын 12




Нийтийн хоолны салбарын орлого өмнөх сараас 32.2 хувиар өсжээ

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны эхний 8 сард 352.9 тэрбум төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 38.8 (9.9%) тэрбум төгрөгөөр буурчээ. Үүнд рестораны орлого 36.7 (16.1%) тэрбум төгрөг, гуанзных 4.2 (7.9%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Харин захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлого өмнөх оны мөн үеэс 3.8 (5.1%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Нийтийн хоолны салбарын орлого 2021 оны оны 6 дугаар сард 50.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 12.7 (33.6%) тэрбум төгрөг, 7 дугаар сард 51.8 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 1.3 (2.6%) тэрбум төгрөг, 8 дугаар сард 68.5 тэрбум төгрөг болж, өмнөх сараас 16.7 (32.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна.

ЗУРАГ 1. НИЙТИЙН ХООЛНЫ САЛБАРЫН ОРЛОГО¹,
төрлөөр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 8 сард



Нийтийн хоолны салбарын нийт орлогод рестораны орлого 54.0 хувь, захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээнийх 22.5 хувь, гуанзных 13.8 хувь, кафеных 7.4 хувь, баарных 2.3 хувийг тус тус эзэлж байна. Захиалгат хоолны хүргэлтийн үйлчилгээний орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 3.2 нэгж хувь, кафеных 0.4 нэгж хувь, гуанзных 0.3 нэгж хувь, баарных 0.1 нэгж хувиар өсөж, харин рестораны орлогын эзлэх хувь 4.0 нэгж хувиар буурсан байна.


Зочид буудлын салбарын орлого өмнөх сараас 45.2 хувиар өсжээ

Зочид буудлын салбарын орлого 2021 оны эхний 8 сард 108.9 тэрбум төгрөгт хүрч, өмнөх оны мөн үеэс 2.4 (2.1%) тэрбум төгрөгөөр буурсан байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 3.7 (5.2%) тэрбум төгрөгөөр буурсан нь голлон нөлөөлсөн байна. Харин зэрэглэлгүй зочид буудлын орлого 1.8 (4.9%) тэрбум төгрөгөөр өссөн байна.

Зочид буудлын салбарын орлого 2021 оны 7 дугаар сард 16.3 тэрбум төгрөгт хүрч, өмнөх сараас 4.2 (34.8%) тэрбум төгрөгөөр, 8 дугаар сард 23.6 тэрбум төгрөгт хүрч өмнөх сараас 7.4 (45.2%) тэрбум төгрөгөөр тус тус өссөн байна. Үүнд 3 ба түүнээс дээш одтой буудлын орлого 4.4 (45.2%) тэрбум төгрөг, зэрэглэлгүй зочид буудлын орлого 2.7 (42.7%) тэрбум төгрөгөөр өссөн нь голлон нөлөөлсөн байна.

Зочид буудлын салбарын 2021 оны эхний 8 сарын орлогын 61.9 хувийг 3 ба түүнээс дээш одтой зочид буудал, 36.2 хувийг зэрэглэлгүй зочид буудал, амралтын газар, 1.9 хувийг 2 одтой зочид буудлын орлого эзэлж байна.

ЗУРАГ 2. ЗОЧИД БУУДЛЫН САЛБАРЫН ОРЛОГО, зэрэглэлээр, тэрбум төгрөг, жил бүрийн эхний 8 сард



Зочид буудлын салбарын орлогод 3 ба түүнээс дээш одтой буудлын орлогын эзлэх хувь өмнөх оны мөн үеэс 2.0 нэгж хувь, 2 одтой зочид буудлынх 0.5 нэгж хувиар буурч, зэрэглэлгүй зочид буудлын орлого 2.4 нэгж хувиар өссөн байна.

Ойлголт, тодорхойлолт

Нийтийн хоолны салбарт ресторан, кафе, баар, гуанз, захиалгат хоол хүргэх, үйлчлэх үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгжүүдийг хамруулна.

Зочид буудлын үйл ажиллагаанд зочид буудал, амралтын газар, хүүхдийн зуслан, түр хоноглох байруудын үйл ажиллагаа хамрагдана.



Эх үүсвэр

Нэмэгдсэн өртгийн албан татвар төлөгч хуулийн этгээдийн мэдээллийн сан

Ангилал, код

Эдийн засгийн бүх төрлийн үйл ажиллагааны салбарын ангилал.

Мэдээлэл авах холбоос

<http://www.nso.mn/>
<http://www.1212.mn/>

Дараагийн мэдээ тархаах хуваарь

2021 оны 11 дүгээр сарын 17

Эдийн засгийн статистикийн газрын
дарга А.Дэмбэрэл
Утас : (976-51)-329278

Эдийн засгийн статистикийн газрын
статистикч Ч.Мөнхтуул
Утас : (976-51)-264797



/StatisticMGL



information@nso.mn



1900-1212